



2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ


Шинэ үнэт цаас болон ХК-ийн бүртгэл

Монголын хөрөнгийн биржиг шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 3 компани хүсэлтээ ирүүлсэнийг судалж, нийт **773,764,278 ширхэг үнэт цаасыг** шинээр бүртгэж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох шийгвэр, дүгнэлтийг хүргүүлснээс **“Инвескор ББСБ” ХК, “Мост Финтек”, “Богь даатгал” ХК-иудын зөвшөөрөл гарсан хэдий ч “Мост Финтек” ХК нь анхдагч зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгохгүйгээр буцаан хасагдах хүсэлтээ өгсний дагуу зохих шийгвэрийг гаргасан. Харин 2018 онд СЗХ-ны холбогдох шийгвэр гарсан “Түмэн шувуут” ХК, “Ард кредит ББСБ” ХК, “Монос хүнс” ХК, “Инвескор ББСБ” ХК-иуд МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар **нийт 42.4 тэрбум төгрөгийг** олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн байна.**



Бүртгэлийн өөрчлөлт – Хувьцаа хуваах

“Мангал даатгал” ХК-ийн нийт 6,243,016 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 100 хувааж нийт 624,301,600 ширхэг болгон бүртгэсэн. Мөн “Баян-Алгар” ХК, “Дархан гурил тэжээл” ХК-иудын хувьцаа хуваах хүсэлт ирүүлсэнийг шийгвэрлэж, зохих дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлээг байна.





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Бүртгэлтэй компанийн нэгдэл



Монголын хөрөнгийн биржиг бүртгэлтэй **"Хорго хайрхан" ХК**-г **"Монгол даатгал" ХХК** нэгдэхээр хүсэлтээ ирүүлсэнийг шийгвэрлэж, зохих дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонг хүргүүлсэнээр СЗХ-ны шийгвэр 2019 оны 12-р сарын 16-ны өдөр гарсан байна.

Бүртгэлийн бусад өөрчлөлт



"Дархан гурил тэжээл" ХК, **"Шарын гол" ХК**-иудын нэмж үнэт цаас гаргах, өрийг хувьцаагаар солих хүсэлт ирүүлсэнийг судалж, "Дархан гурил тэжээл" ХК-ийн хүсэлтийг буцаасан бол, "Шарын гол" ХК нь хүсэлтээ буцаан татсан байна. Нэр өөрчлөх хүсэлтээ ирүүлсэн **3 ХК-ийн** нэрийг өөрчилж, холбогдох шийгвэр, дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонг хүргүүлсэн.

Биржийн бүртгэлээс хасах



Бүртгэлтэй үнэт цаасны чанарыг сайжруулах зорилгоор бүртгэлийн шалгуур, шаардлага хангахгүй байгаа нийт 21 ХК-ийг Биржийн санаачлагаар буюу Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу, харин **"Баялаг налайх" ХК**, **"Мост Финтек" ХК**-иудын хувьцааг үнэт цаас гаргачийн хүсэлтээр тус тус МХБ-ийн бүртгэлээс хасааг байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Биржийн гишүүн ҮЦК



2019 онд Монголын хөрөнгийн биржиг шинээр 2 үнэт цаасны компани /"Монгол хувьцаа" ХХК, "Домикс ҮЦК" ХХК/ гишүүнээр элсэж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон "Фронтинер ҮЦК" ХХК болон "Эм Даблью Ти Эс ҮЦК" ХХК-уудыг биржийн гишүүнчлэлээс хассанаар нийт 59 үнэт цаасны компани болон 4 кастодиан банк үйл ажиллагаа явуулж байна.


Засгийн газрын үнэт цаас




Тайлант хугацаанд Сангийн яамнаас дотоодын зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой биржиг шинээр нэмж ЗГҮЦ-ыг бүртгээгүй буюу анхдагч зах зээлийн арилжаа огт явагдаагүй. Харин 56.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж 568,515 ширхэг ЗГҮЦ-ыг биржийн бүртгэлээс хассан.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Нээлттэй өгөрлөг



Орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор 2017 оноос эхлэн зах зээлийн зохицуулагч болон мэргэжлийн байгууллагууд, "Эргэнэс Тавантолгой" ХК-тай хамтран "Хөрөнгийн зах зээлийн нээлттэй өгөрлөг"-ийг зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2019 онд **Өвөрхангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ** зэрэг **нийт 12 аймгийн төв болон 30 сумдаг** амжилттай зохион байгуулж **нийт 15,000 гаруй иргэдэг**:

- 
- хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд,
 - хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох,
 - хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулсан байна.

Мөн **"Эргэнэс Тавантолгой" ХК-ийн** үйл ажиллагаа, иргэдэг олгосон хувьцааны талаарх гэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, үнэт цаасны данс нээх нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.



ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛТҮҮД

Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам



Мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдгээрийн нэгж эрхийг Бирж бүртгэж, арилжааг зохион байгуулснаар хөрөнгө оруулагчид биржээр дамжуулан хамтын хөрөнгө оруулалтын сангуудаг хөрөнгө оруулж, оновчтой удирдлагаар хангагдах давуу талтай юм. Иймд МХБ-ээс “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулж, МХБ-ийн ТҮЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тоот тогтоолоор батлуулан, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр СЗХ-гоор батламжлуулааг байна.


Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам




Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан МХБ-ийн ТҮЗ-ийн 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 2019/11 тоот тогтоолоор энэхүү журамд хэд хэдэн өөрчлөлтийг оруулан 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр СЗХ-оор батламжлуулснаар дагаж мөргөж эхлээг байна.



НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН




ХУВЬЦААНЫ АРИЛЖАА






ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХЖИЛТ

2019 онд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээс “Түмэн шувуут” ХК-ийн хувьд 9.1%-аар, “Ард кредит ББСБ” ХК-ийн хувьд 3 дахин их, “Монос хүнс” ХК-ийн хувьд 21%-аар, “Инвекор ББСБ” ХК-ийн хувьд 15.9%-аар тус тус давсан үзүүлэлттэй байсан нь хөрөнгийн зах зээлд сонирхогч болон оролцогчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжсэнийг харуулж байна.





ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСУУД



ТАЙЛАНТ ХУГАЦААНД ТОП-20 ИНДЕКСИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ **19,978.13** НЭГЖ БАЙНА. ТОП-20 ИНДЕКСИЙГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД **8.59 ХУВИАР БУУРЧ 19,621.86** НЭГЖ БОЛСОН БАЙНА.


"ТОП-20" ИНДЕКСИЙН САГСЫГ ЖИЛД НЭГ УДАА ШИНЭЧИЛДЭГ БӨГӨӨД 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР САГСЫГ ШИНЭЧЛЭХЭД ӨМНӨХ САГСАД БАГТАЖ БАЙСАН 11 КОМПАНИ ХЭВЭЭР ҮЛДЭЖ, ШИНЭЭР "ХАЙ БИ ОЙЛ" ХК, "ЖЕНКО ТУР БЮРО" ХК, "ЖИНСТ УВС" ХК, "АЙТУУЛС" ХК, "ЛЭНДМН ББСБ" ХК, "МОНГОЛ БАЗАЛТ" ХК, "ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК, "МАНДАЛ ДААТГАЛ" ХК, "АРД ДААТГАЛ" ХК –УУД НЭМЭГДЭВ.



ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх онтой харьцуулахад **182.2 тэрбум төгрөгөөр** буюу **7.27 хувиар** өсч, **2 их наяд 690.0 тэрбум төгрөг** болсон байна.

Зах зээлийн үнэлгээ – сүүлийн 5 жилээр




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ ТӨХК нь 2019 онд үйл ажиллагаанаас нийт **1.6 тэрбум** төгрөгийн орлогыг олж, **1.4 тэрбум** төгрөгийн зардал гаргаснаар нийт **168.9 сая төгрөгийн цэвэр орлоготой** ажилласан ба МIТ цогц системийн ашиглалтын зардал болон элэгдэл, хорогдолд нийт **1.2 тэрбум төгрөгийн зардлыг хуримтлуулж тооцсоноор** санхүүгийн тайлангаа татварын өмнөх байглаар **1.1 тэрбум** төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөг байна.




НИЙТ ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ ТӨХК нь 2019 онд үйл ажиллагаанаас нийт **1,554.6 сая төгрөгийн орлогыг** олж ажилласан ба өмнөх онтой харьцуулахад **арилжааны шимтгэлийн орлого 19.8%-аар** буурсан нь хоёрдогч зах зээлийн арилжааны дүн буурсантай холбоотой байна.





НИЙТ ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МХБ ТӨХК нь зах зээлийн гэгэ бүтэц болох MIT цогц системийн ашиглалттай холбоотой бүхий л зардлыг дангаар хариуцаж буйтай холбоотой **жилд дунджаар 1.2-1.3 тэрбум төгрөгийн зардлыг** санхүүгийн тайлангаа хүлээн зөвшөөрснөөр ийнхүү алдагдалтай ажилласан байна. Тэсэн хэдий ч **2019 онд Улсын төсөвт нийт 458.6 сая төгрөгийн татвар, хураамж, шимтгэлийг төлсөн.**



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК

Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот, Монгол Улс

Факс: (976)-11-325 170

Веб хуудас: www.MSE.mn